



**“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН  
ДЭЭД БОЛОВСРОЛ” ТӨСӨЛ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Бага тойруу, ШУТИС-ийн төв номын сангийн 605 тоот

Утас: 31-55-63, Факс: (976-11)31-55-63

Вэб хаяг: [www.m-jeed.edu.mn](http://www.m-jeed.edu.mn)

2015-06-08 № 101  
таний ны № -т

МОНГОЛ УЛСЫН ИХ  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Р.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Багш, судлаачдыг зэргийн  
сургалтад хамруулах тухай

“Инженер, технологийн дээд боловсрол” төслийн санхүүжилтээр Япон Улсын их, дээд сургуулиудад 2015 оны 10 дугаар сараас эхлэн магистр, докторын сургалтын хөтөлбөрт элсэн суралцах багш, судлаачдын урьдчилсан бүртгэлийг сургуулийн ажлын хэсэг дээрээ хийж, тавигдах шаардлагыг хангаж буй багш, оюутны нэрс болон холбогдох мэдээллийг 2015 оны 7 сарын 10-ны дотор Төсөл хэрэгжүүлэх нэгжид ирүүлнэ үү.

**Магистрын сургалтын хөтөлбөр:**

**Суралцах хугацаа:** Япон Улсад - 2 жил хүртэл

**Хамрах хүрээ:**

- Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан болон магистрын зэрэггүй багш нар;
- МУИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтан;

**Тавигдах шаардлага:**

- Монгол Улсын иргэн байх, 35 нас хүртэл;
- Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
- Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;
- Японы их сургуульд элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
- Сургууль /ажлын газар/ нь магистрын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;

- e/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсөн байх;

**Докторын сургалтын хөтөлбөр:**

**Суралцах хугацаа:** Япон Улсад - 3 жил хүртэл

**Хамрах хүрээ:**

- a/ Инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр МУИС-д ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, докторын зэрэггүй багш нар;
- b/ МУИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр тэргүүлэх чиглэлийн судалгааны сэдвээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хамтран ажиллаж буй багш, судлаачид, болон эрдэм шинжилгээний ажилтан;

**Тавигдах шаардлага:**

- a/ Монгол Улсын иргэн байх, 40 нас хүртэл;
- b/ МУИС-д инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр ажиллаж буй багш, ажилтан
- v/ Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их, дээд сургуулийг инженер, технологи, байгалийн ухааны чиглэлээр суралцаж төгссөн байх;
- g/ Гадаад хэлний шалгалт: Япон хэлний түвшин тогтоох JLPT шалгалтын N2 түвшин, эсвэл Англи хэлний TOEFL шалгалтын оноо PBT-500, IELTS шалгалтын оноо 5.0 ба түүнээс дээш байх;
- d/ Японы их, дээд сургуулиудад элсэн суралцах болзол хангаж, суралцах урилга хүлээн авсан байх;
- e/ Сургууль /ажлын газар/ нь докторын хөтөлбөрт суралцахыг дэмжсэн байх;
- ë/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ болон уг гэрээний хавсралт болох үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсөн байх;

**Дээрх шаардлагыг хангасан нэр дэвшигчдийн бүрдүүлэх материалын жагсаалт**

- a/ Анкет; /маягтын дагуу/
- б/ Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- v/ Бакалавр /магистр/-ын дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- g/ Япон, эсвэл Англи хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн батламжийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /Сүүлийн 2 жилд өгсөн байх/;
- d/ Япон талын их, дээд сургуулиас ирүүлсэн суралцах эрхийн бичиг;
- e/ Сургуулийн /ажлын газрын/ тодорхойлолт;
- ë/ Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт;
- ж/ Судалгааны ажлыг удирдаж буй хоёр талын их сургуулийн профессорын тодорхойлолт;
- з/ Судалгааны ажлын төлөвлөгөө;

- и/ Сургуулиа төгсөөд эх орондоо мэргэжлээрээ хэрхэн ажиллах тухайгаа Монгол-Англи, эсвэл Монгол-Япон хэл дээр бичсэн 700-800 үтгэй эссэ;
- й/ Суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх гэрээ, уг гэрээний хавсралт болох ул хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний нөхцлийг зөвшөөрсний үндсэн дээр элсэхийг хүссэн өргөдөл /Маягт харгалзахгүй/;
- к/ Зх4 хэмжээтэй 2 хувь цээж зураг /Сүүлийн 3 сард авахуулсан байх/;
- л/ Бүртгэлийн хураамж;

ЗОХИЦУУЛАГЧ

“ИТДБ” төсөл

МУИС-ийн төв номын

сангийн 605 тоот

Утас: +(976) 11-315563

Е-шуудан: piu1000@mecs.gov.mn



Д.НАМСРАЙ